



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/351

Ховд

Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “А” заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Баруун бүсийг мал амьтны гоц халдварт өвчнөөр тайван бүсээр тогтоож, махны экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлого зорилтын хүрээнд олон улсын худалдааны хорио цээрт мал амьтны гоц халдварт өвчин дамжин тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 7 дугаар сарын 05-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд тус аймгийн нутаг дэвсгэрт Зүүн болон төв, хангайн бүсийн аймгуудаас мал амьтан оруулах, шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосугай.

2. Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тархвар зүйн судалгаа хийх ажлыг жил бүр төлөвлөн зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Мал эмнэлгийн газар /Д.Батцэнгэл/-т даалгасугай.

3. Мал амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг чангатган Мал эмнэлгийн нэгдсэн системийг тогтмол хянаж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэж, захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг нийт сум, багийн Засаг дарга, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ